



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 4 дүгээр хэсгийн 4.5.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/424 дүгээр тушаалаар байгуулагдсан Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Буддын сүм хийдүүд болон хувиараа "Алтан сав" нээдэг зурхайч, лам нарын бүртгэл судалгааг гаргах, тэдгээртэй харилцан ойлголцох санамж бичгийн төсөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, захицуулалтын хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч С.Аригууныг, ажлын хэсгийн гишүүнээр "Буяны зан үйлийн холбоо" ТББ-ын тэргүүн Г.Идэрмааг тус тус өөрчлөн томилсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/424 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонд тооцсугай.

3. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан ажлыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг /С.Аригуун/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР

